

35 кВ-ын ЦДАШ-ын төмөр бетон тулгууруудын төмөр хийцүүдийг

будах ажлын даалгавар, тоо хэмжээ

Ерөнхий шаардлага:

1. УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн 32 анкер тулгуур 449 завсрын төмөр бетон тулгуур нийт 481 ш тулгуур будах.
2. Ус чийгний хамгаалалттай FUXI брэндийн /түүнтэй дүйцэхүйц/ цахилгаан тоноглолын метал хийц будах зориулалттай зэврэлтэд тэсвэртэй мөнгөлөг саарал өнгийн /3209100000/ будагаар будах.
3. Будгийн ажлыг чанартай сайн хийж гүйцэтгэх, будсан тулгуурууд ашиглалтын хугацаанд 3 аас доошгүй жил үндсэн өнгөө алдахгүй, ховхорч унахгүй, бороо усанд тэсвэртэй байх. Чанартай сайн гэдгийг дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - a. Будаг төмөр хийцэд жигд зузаантай түрхэгдсэн байх.
 - b. Нэгэн жигд бус энд тэнд цоохортуулж будахгүй байх.
4. Хэрэв төмөр хийц будсан будаг нь баталгаат хугацаанд ховхорч унах, бороо усанд урсаж арилах, алаг цог болох зэрэг тохиолдолд гүйцэтгэгч компани нь өөрсдийн хөрөнгөөр төмөр хийцийг дахин будах шаардлагатай.

Д/д	Шугамын нэр	Анкер тулгуурын тоо	Бетон тулгуурын тоо	Нийт тулгуурын тоо
1	35 кВ-ын Газрын тос ЦДАШ	У35-1 – 8 ш		8
2	35 кВ-ын Баян-Өнжүүл ЦДАШ	У35-1т (1 хэлхээт тростой) – 4 ш У35-1 – 16 ш	ПБ35-1 – 434 ш ПБ35-1т – 15 ш (т-тросстой)	469
3	35 кВ-ын Цэвэрлэх ЦДАШ	У35-2т -4 ш (2 хэлхээт, тросстой)	-	4
	Нийт	32	449	481

Будгийн ажил хийх компанд тавигдах шаардлага:

1. Будгийн ажил хийх компани нь ЦДАШ-ын төмөр хийцийг будаж байсан 1-ээс доошгүй жилийн туршлагатай байх.
2. Будгийн ажил хийх компани нь 35 кВ-ын сүлжээнд угсралтын ажил хийх тусгай зөвшөөрөлтэй байх.
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан инженертэй байх
4. Будгийн ажил хийх ажилтнуудыг хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан байх /Хамгаалах бүс, каска, дөрөө, будгийн ажлын хувцас, халтирдаггүй ултай гутал гэх мэт /
5. Хамгаалах хэрэгслүүдийг туршилт хийж баталгаажуулсан байх

Будгийн ажил хийх бригадын ажилтнуудад тавигдах шаардлага:

1. Будгийн ажил хийх бригад нь цахилгаан байгууламжийн дүрмийн мэдлэгтэй ажилтнуудтай байх
2. Бригадын ажилтнууд нь өндөрт ажиллах эрхтэй, АА-ны III доошгүй групптэй байх
3. Бригадын ажилтнуудыг удирдаж ажиллах ажлын удирдагч нь тухайлсан зааварчилгаа болон бусад зааварчилгааг бригадын гишүүдэд өгч чадах мэдлэгтэй байх
4. Аюулгүй ажиллагааны нарядын дагуу ажлыг зөв зохион байгуулах.

Машин механизмд тавигдах шаардлага:

1. Будгийн ажил хийх бригад нь өндөрт ажиллах тул сунадаг тусгай зориулалтын машин механизмтай байх. /Тулгуурын өндөрт нийцсэн 26м-аас доошгүй урттай/
2. Тусгай зориулалтын машин механизмын жолооч нь аюулгүй ажиллагааны групптэй байх ёстой.

Будганд тавигдах шаардлага:

д/д	Өгөгдөл	Үзүүлэлт
1	Cas №	3209100000
2	Өнгө	Мөнгөлөг саарал
3	Загвар	FX-101
4	Хэрэглээний төрөл	Цахилгаан тоноглолын метал хийц будах зориулалттай зэврэлтэд тэсвэртэй
5	Төлөв байдал	Шингэн
6	Будагны зуурамтай чанар	63%
7	Орчины чийгшил	85% хүртэл хэрэглэх
8	Брэндийн нэр	FUXI /дүйцэхүйц
9	30µm/coat	0.1кг=1м2

Бусад:

1. Будгийн ажил гүйцэтгэх үед гарах зардлыг гүйцэтгэгч тал хариуцна.
2. 2017 оны 6 сарын 12 ны А/81 чөлөөт зах зээл дээрх төлбөрт үйлчилгээний үнийг шинэчлэн батлах тухай тушаалыг үндэслэн дараах төлбөрт үйлчилгээг тарифын дагуу гүйцэтгэгч захиалагч талд төлнө.
 - 2.1. Наряд олгох
 - 2.2. Таслалт хийх, залгалт хийх
 - 2.3. Хянагч томилох /ажлын бус цагаар ажиллуулах тохиолдолд хянагчийн ажилсан цагийг хоёроор үржүүлж төлбөрт үйлчилгээний тарифын дагуу тооцно./